



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 817

Улаанбаатар хот

Г Дархлаажуулалтын тухай

Дархлаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл (ДДУХ)-ийг тандах журмыг нэгдүгээр, ДДУХ-ийн ангилалыг хоёрдугаар, ДДУХ-ийг яаралтай мэдээлэх хуудсыг гуравдугаар, ДДУХ-ийн судалгааны хуудсыг дөрөвдүгээр, ДДУХ-ийн бүртгэлийн хуудсыг тавдугаар, ДДУХ-ийн лабораторийн шинжилгээ авах зааврыг зургаадугаар, Дархлаажуулалтын кабинетийн ажиллах журмыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2004 оны 242 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД  
Н.ХҮРЭЛБААТАР

133531

Эрүүл мэндийн сайдын 2012  
оны 6. сарын 27. өдрийн 27. тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл (ДДУХ)-ийг  
тандах журам

Улс, хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллага  
дархлаажуулалтын дараах урвал хүндрэлээс сэргийлэх, илрүүлэх, бүртгэх,  
мэдээлэх, судлах, тандах үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдөнө.

ДДУХ гэж дархлаажуулалтын дараа хүний эрүүл мэндэд учирсан  
тогтвортой, эсхүл ноцтой хямралыг хэлнэ. ДДУХ-ийн шалтгааныг  
дархлаажуулалтын үйл ажиллагааны алдаа, вакцинаас үүдэлтэй эсвэл эрүүл  
мэндийн эмгэг байдал нь вакцин тарьсан цаг хугацаатай давхцаж илэрсэн,  
шалтгаан тодорхойгүй гэж ангилан үздэг.

Энэхүү журмыг хэрэгжүүлснээр ДДУХ-ээс сэргийлэх, илрүүлэх, тандан  
судлах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа сайжрах  
юм.

1. Сум, өрхийн эмч, улс, хувийн хэвшлийн эмнэлгийн нярайн  
эмчийн гүйцэтгэх үүрэг

1.1. Хүүхдэд дархлаажуулалт хийх тохиолдол бүрийн өмнө эрүүл  
мэндийн үзлэг хийнэ. Эхий жирэмслэлт, төрөлтийн явц, удмын байдал,  
хүүхдийн бие сэтгэцийн өсөлт, өвчилж байсан өвчин, урьд нь вакцин  
тариулсаны дараа урвал хүндрэл илэрч байсан эсэхийг судална.  
Дархлаажуулалт хийхэд эсрэг заалт байгаа эсэхийг тогтоож, харшлах заалт  
илэрсэн хүүхдэд эмчилгээ хийж эрүүлжүүлж, цаашид ямар вакцинаар, ямар  
товлогоор хийхийг тогтоож өгнө.

1.2. Мэдрэлийн талаас эмгэгтэй, амьсгалын замын болон бусад өвчнөөр  
байнга өвчилдөг, урьд нь дархлаажуулсны дараа урвал, хүндрэл илэрч байсан,  
өндөг болон ямар нэгэн эмийн зүйл хэрэглэсний дараа харшил илэрч байсан  
хүүхдийг дархлаажуулах асуудлыг шийдвэрлэнэ.

1.3. Тухайн хүүхдийг дархлаажуулах талаар хүүхдийн эрүүл мэндийн  
дэвтэр, нярайн түүхэнд тэмдэглэл хийнэ. Тухайн өдөр хүүхэд ямар вакцины  
хэддүгээр тун хийлгэхийг бичнэ.

1.4. ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг Цочмог сул  
саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7  
хоног бүр харьяа аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд  
утсаар мэдээлнэ.

1.5. ДДУХ илэрсэн үед яаралтай тусламж үзүүлж, шаардлагатай  
тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

1.6. ДДУХ-ийн тохиолдлын үед энэхүү тушаалын гуравдугаар хавсралтын  
дагуу 24 цагийн дотор аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан  
мэргэжилтэнд утсаар мэдээлнэ.

1.7. ДДУХ-ийн тохиолдол бүрийг энэхүү тушаалын тавдугаар хавсралтын  
дагуу бүртгэнэ.

1.8. ДДУХ-ийн тохиолдол бүрийг энэхүү тушаалын дөрөвдүгээр  
хавсралтын дагуу судалгаа хийж нэг хувийг аймаг, дүүргийн дархлаажуулалт

хариуцсан мэргэжилтэнд явуулж, хоёрдахь хувийг байгууллага дээрээ хадгална.

1.9. Вакцин, зүү тариураас дээж авч зургаадугаар хавсралтын дагуу аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан эмчид хүргүүлнэ.

1.10. ДДУХ-ийн сарын мэдээг өргөн дархлаажуулалтын хамралтын мэдээтэй хамт аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ.

1.11. ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдсэн тухайн сум, орон нутагт олон тохиолдол ажиглагдсан эсэхийг тогтоох идэвхтэй тандалт хийнэ.

1.12. Дархлаажуулалтын дараа гарч болох урвал, хүндрэлийн талаар эцэг, эхчүүдэд мэдлэг олгож, илэрсэн тохиолдолд нэн даруй эмнэлэгт хандах тухай зөвлөгөө, зөвлөмж өгнө.

## 2. Аймаг, нийслэл, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг

2.1. Сум, өрхийн эмч, улс, хувийн хэвшлийн эмнэлгийн нярайн эмчээс мэдээлсэн ДДУХ-ийн "0" тохиолдлын мэдээг нэгтгэн ЦСС болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны 451798 тоот утсаар мэдээлнэ.

2.2. ДДУХ-ийн тохиолдлыг энэхүү тушаалын гуравдугаар хавсралтын дагуу ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга, аюулгүй дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар яаралтай мэдээлнэ.

2.3. ДДУХ-ийн тохиолдлын сар бүрийн мэдээг өргөн дархлаажуулалтын сарын тайлантай хамт гаргаж дараа сарын 10-ны дотор ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд ирүүлнэ.

2.4. ДДУХ-ийн тохиолдлын мэдээ авмагц аймаг, нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга мэргэжлийн баг (дархлаажуулалт хариуцсан их эмчээр ахлуулсан, хүүхдийн зохицуулах мэргэжилтэн, мэдрэлийн эмч, чанарын менежер, нян судлал, клиник лабораторийн эмч, мэс заслын эмч гэх мэт бусад эмчийн бүрэлдэхүүнтэй)-ийг томилон ажиллуулна.

2.5. ДДУХ-ийн тохиолдолд мэргэжлийн баг нь эмнэлгийн тусlamж үйлчилгээ, судалгаа, хариу арга хэмжээнд дүгнэлт хийнэ.

2.6. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн сэжигтэй өвчтөнд үзүүлж байгаа эмнэлгийн тусlamж үйлчилгээг хянаж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.7. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг аймаг, нийслэл, дүүргийн эмбиобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын улсын алба, эмчилгээний чанарын хяналтын байцаагчид мэдээлж, магадлан тогтоолгоно.

2.8. Вакцин, зүү тариурын сорьц, өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгүүлж хариуг албан ёсоор хүргүүлнэ.

2.9. Цаг хугацаа, газар зүйн адил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол байгаа эсэхийг илрүүлэх идэвхтэй тандалт (хүүхдийн эмнэлэг, тасагт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөн, өвчний түүх, үзлэгийн журнал, дуудлагын хуудас, хүлээн авахын бүртгэл)-ыг зохион байгуулна.

2.10. ДДУХ-ээс сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгнө.

### 3. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн гүйцэтгэх үүрэг

3.1. ДДУХ-ийн тандалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил, аргазүйн удирдлагаар хангана.

3.2. ДДУХ-ийн “0” тохиолдлын мэдээг долоо хоног бүр, ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг 24 цагийн дотор ЭМЯ-ны халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэнд мэдээлнэ.

3.3. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлын үед захирлын тушаалаар тандалт судалгаа хийн дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн баг (дэд захирлаар ахлуулсан, аюулгүй дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн эмч, мэдрэлийн эмч, чанарын менежер, мэс заслын эмч, нян судлагч эмч, клиникийн лабораторийн эмч болон бусад мэргэжлийн эмч нарийн бүрэлдэхүүнтэй)-ийг томилон ажиллуулна.

3.4. Шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн яамны баг ажиллуулах санал тавина.

3.5. ДДУХ-ийн тохиолдлыг Эрүүл мэндийн яам, Засгийн газрын тохируулагч агентлаг -Эрүүл мэндийн газарт сар бүр мэдээлнэ.

3.6. ДДУХ-ээс сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, судлах, тандалт хийх, хариу арга хэмжээ авах талаар аймаг, нийслэл, дүүргийн халдварт судлагч, лабораторийн эмч, улс, хувийн хэвшлийн хүүхдийн эмнэлэг, тасгийн эмч, сувилагч нарт сургалт зохион байгуулна.

3.7. Аймаг, нийслэлийн улс, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагад ДДУХ-ийн тандалт, хариу арга хэмжээний талаар улирал тутам эргэн мэдээлэл явуулна.

3.8. ДДУХ-ийн тандалтыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.


### 4. Улс, хувийн хэвшлийн хүүхдийн эмнэлэг, тасгийн эмч нарын гүйцэтгэх үүрэг

4.1. Эмчлүүлж буй хүүхдүүдийн дунд энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол илэрвэл бүртгэж, харьяа аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд уг тушаалын гуравдугаар хавсралтын мэдээлэх хуудасны дагуу 24 цагийн дотор мэдээлнэ.

4.2. Аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан эмчээр ахлуулсан ДДУХ-ийг судлах мэргэжлийн багтай хамтран энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу судалгаа хийж, эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын байцаагчаар дүгнэлт гаргуюулна.

4.3. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдолд эмнэл зүйн шинж, лабараторийн шинжилгээний талаарх мэдээллийг мэргэжлийн багт гаргаж өгнө.

Эрүүл мэндийн сайдын 2012  
оны 6 сарын 27-өдрийн 27 тоот  
тушаалтын хоёрдугаар хавсралт



## ДДУХ-ийн ангилал

Цаг хугацааны хувьд дархлаажуулалт хийлгэсэнтэй хамааралтай хүүхдэд илэрсэн бүх эмгэг тохиолдлуудыг бүртгэн мэдээлнэ. Энэхүү ангилалд дархлаажуулалт хийлгэсэнээс хойш 4 долоо хоногийн хугацаанд илэрч болох тохиолдлууд хамаарна.

### 1. Хэсэг газрын урвал

#### 1.1. Тарилга хийлгэсэн газрын буглаа

Тарилга хийлгэсэн газарт битүү эсвэл нээлттэй нэвчдэст шингэнээр дүүрсэн эмгэг өөрчлөлт үүссэн байх. Халуурах эсвэл халуурахгүй байж болно.

-Нянгийн: Идээтэй, үрэвслийн шинж тэмдэг илэрсэн, халуунтай. Буглааны агуулагдахуунд нейтрофиль эс давамгайлсан, Грамаар будагдсан нян харагдсан, нян өсгөвөрлөх шинжилгээ зэрэг байх. Гэвч эдгээр шинжийн аль нэг илрээгүй байх нь оношийг бүрэн үгүйсгэхгүй.

- Цэвэр: Нянгийн халдвар байж болох ямар нэг шинж тэмдэг илрээгүй бол цэвэр буглаа гэж үзнэ.

#### 1.2. Лимфаденит

Дараах шинж тэмдгийн аль нэг илэрсэн байх. Үүнд:

- Тунгалагийн булчирхай 1.5 см (насанд хүрсэн хүний хурууны өргөн) түүнээс илүү томорсон байх;
- Тунгалагийн булчирхайд нээлттэй синус үүссэн байх.

Гол төлөв БЦЖ вакцин тарьсаны дараа 2-6 сарын дотор тарилга хийлгэсэн талд (ихэвчлэн суганы булчирхайд) үүснэ.

#### 1.3. Хэсэг газрын хүнд урвал

Тарилга хийлгэсэн газар хавдаж улайхын зэрэгцээ дор дурьдсан шинж тэмдгийн аль нэг илэрсэн байх. Үүнд:

- Хамгийн ойрын үеэнд хүртэл хавагнах,
- Хөндүүрлэлт, улайлт, хаван зэрэг шинж тэмдэг З хоногоос дээш хугацаагаар үргэлжлэх.

### 2. Төв мэдрэлийн тогтолцоонд илрэх сөрөг нөлөөлөл

#### 2.1. Цочмог сул саажилт/ЦСС/\*

- Вакцинаас хамаарсан саажилт бүхий полиомиелит:

Халдварт саагийн эсрэг вакцин уусны дараа 4-30 хоногт эсвэл вакцинд хамрагдсан хүнтэй хавьтал болсноос хойш 4-75 хоногийн дотор захын мэдрэлийн сул саажилт цочмог эхлэх, 60 хоногийн хугацаанд мэдрэлийн системийн үйл ажиллагааны алдагдлын шинж тэмдгүүд үргэлжлэн илрэх.

- Гиллен-Баррын хам шинж (GBS): Хоёр талыг ижил хамарсан сүл саажилт, цочмог эхэлж хурдацтайгаар өгсөх чиглэлтэйгээр даамжирна. Ихэвчлэн халуурдаггүй бөгөөд мэдрэхүй алдагдана. Тархи нугасны шингэнд эсийн тоо ба уургийн агууламжид зөрөө илэрснээр тухайн тохиолдлын онош баталгаажна. Дархлаажуулалтад хамрагдсанаас хойш 30 хоногийн дотор илэрсэн Гиллен-Баррын хам шинжийг бүртгэж мэдээлнэ.

## 2.2. Энцефалопати (тархины эдийн эмгэгшил)

Дархлаажуулалт хийлгэсэн цаг хугацаатай давхцан илэрч буй цочмог эмгэг бөгөөд дараах түрүүнээс дээш хоногоор ухаан алдах

- Таталт
- Нэг буюу түүнээс дээш хоногоор ухаан алдах
- Нэг буюу түүнээс дээш хоногоор зан үйл нь эрс өөрчлөгдөх

Дархлаажуулалтад хамрагдсанаас хойш 72 цагийн дотор илэрсэн тохиолдлыг бүртгэж мэдээлнэ.

## 2.3. Энцефалит (тархины эдийн үрэвсэл )

Энцефалопатийн үед илрэх эмнэлзүйн болон тархины эдийн үрэвслийн шинж тэмдгүүд илэрч, тархи нугасны шингэнд (ТНШ)-нд плейцитоз оношлогдох буюу вирус өсгөвөрлөгдөнө. Дархлаажуулалтад хамрагдсанаас хойш 1-4 долоо хоногийн дотор илэрсэн энцефалитийн тохиолдлыг бүртгэж мэдээлнэ

## 2.4. Менингит (тархины хальсны үрэвсэл)

Халууралт, хүзүүний хөшингө (Керниг-Брудзинскийн шинж) зэрэг менингитийн шинж тэмдэг бүхий цочмог хүнд явцтай эмгэг. Энцефалитийн шинж тэмдэг илэрч болох бөгөөд ТНШ-нд плейоцитоз болон нян илэрнэ(Граммын аргаар будах ба нянг өсгөвөрлөнө).

## 2.5. Таталт

Төв мэдрэлийн голомтот өөрчлөлтийн шинж тэмдэггүйгээр, цөөн хэдэн минут болон 15 минутаас илүү хугацаанд үргэлжлэн татах.

- Чичрэгт таталт
- Чичрэггүй таталт

## 3. Бусад урвал, хүндрэл

### 3.1. Харшлын урвал

Дараах шинж тэмдгүүдээс нэг буюу түүнээс дээш нь илрэх эмгэг байдал.  
Үүнд:

- 1) Арьсны эмгэг өөрчлөлтүүд (гүвдрүү, экзем тууралт);
- 2) Амьсгал бачуурах;
- 3) Нүүрний болон бүх биеийн хаван.

### 3.2. Анафилактик хариу урвал (цочмог хэт мэдрэгшлийн хариу урвал)

Дархлаажуулалтад хамрагдсанаас хойш хоёр цагийн дотор цочмог эхэлж дараах шинж тэмдгүүдээс нэг буюу түүнээс дээш шинж тэмдэг илрэх. Үүнд:

- 1) Бронхоспазмын шалтгаант амьсгал бачуурах боогдох шинж;
- 2) Ларингоспазм, төвөнхийн хаван;
- 3) Арьсны эмгэг өөрчлөлтийн нэг буюу түүнээс дээш шинж тэмдэг илрэх (нүүрний хаван, бүх биеийн хаван, гүвдруү)

### 3.3. Анафилаксийн шок

Дархлаажуулсны дараа шууд илрэх цусны эргэлтийн тогтолцооны цочмог хямрал (ухаан алдах, цусны даралт унах, захын судасны лугшилт тэмтрэгдэхгүй болох, захын цусны эргэлт алдагдсантай холбоотой мөчнүүд хөрөх, нүүр улайх гм). Зарим тохиолдолд бронхоспазм, ларингоспазм, төвөнхийн хаваншил явагдсанаас амьсгалын цочмог дутгалд орж болно.

### 3.4 Ye мөчний өвдөлт

Захын жижиг үений өвдөлт.

- Байнгын: Арав ба түүнээс дээш хоног үргэлжлэх үений өвдөлт
- Түр зуурын: Арав хүртэлх хоног үргэлжилсэн үений өвдөлт

### 3.5. БЦЖ вакцины шалтгаант тархмал үрэвсэл

БЦЖ вакциныг хийлгэснээс хойш 1-12 сарын дотор үүсэх тархмал халдварт. БЦЖ вакцины омгийн нянг (*Mycobacterium bovis*) өсгөвөрлөн оношийг баталгаажуулна.

### 3.6. Халууралт

- Бага зэргийн халууралт: Биеийн халуун 38°C -39°C байх (шулуун гэдсэнд)
- Өндөр халууралт: биеийн халуун 39°C -40.4°C байх (шулуун гэдсэнд)
- Маш өндөр халууралт: биеийн халуун 40.5°C ба түүнээс дээш болох (шулуун гэдсэнд)

Зөвхөн өндөр буюу маш өндөр халууралтын тохиолдлыг бүртгэж мэдээлнэ.

### 3.7. Ухаан балартаж унах (даралт унах, муужрах /коллапс/)

Царай цонхийж, гадаад орчинд үзүүлэх хариу урвал буурах, алдагдах, булчингийн тонус сулрах, алдагдах ( дархлаажуулалт хийлгэснээс хойш 24 цагийн дотор илэрнэ). Түр зуурын шинжтэй бөгөөд ихэнх тохиолдолд аяндаа зүгээр болдог.

### 3.8. Ясны болон чөмөгний үрэвсэл (остит/остеомиелит)

БЦЖ вакцин хийлгэснээс хойш 8-16 сарын хугацаанд илэрдэг нянгийн халдвараар үүсгэгддэг ясны үрэвсэлт эмгэг юм.

### 3.9. Чарлах, тасралтгүй чангаар уйлах

- Дархлаажуулалт хийлгэсэн цагаас хойш ойролцоогоор 3 цаг үргэлжилсэн, чарлаж уйлах шинж тэмдэг юм.

### 3.10. Үжил

Нянгийн халдвараас шалтгаалан үүсэх цочмогоор эхэлсэн тархмал, хүнд хэлбэрийн эмгэг юм. Цусанд нян өсгөвөрлөгдсөнөөр онош баталгаажина.

### 3.11. Хордлогын шокийн хам шинж

Дархлаажуулалт хийлгэснээс хэдэн цагийн дотор маш огцом эхэлж халууралт, бөөлжилт, усан суулгаар илэрдэг, ихэвчлэн 24-48 цагийн дотор үхэлд хүргэж ч болно.

Цаг хугацааны хувьд дархлаажуулалтаас хойш 4 долоо хоногийн дотор шалтгаан нь тодорхойгүй нас баралтын тохиолдол бүрийг бүртгэж мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 6...  
сарын 27 өдрийн 17 тоот тушаалын  
гуравдугаар хавсралт

ДДУХ-ийг яаралтай мэдээлэх хуудас

1. Нэгжийн нэр .....
2. Өвчтний овог .....нэр.....нас..... эрэгтэй/эмэгтэй  
(зур)
3. Төрсөн.....он .....сар.....өдөр
4. Хаяг: Аймаг/Дүүрэг..... Сум/хороо.....
5. Мэдээлэгдсэн .....он .....сар.....өдөр.....цаг.....минут
6. Илэрсэн шинж тэмдгийг дэлгэрэнгүй бичих.....  
.....  
.....
7. Өвчтөн: эмнэлэгт / гэрт/ Эмнэлэгт бол хаана:.....
8. Тавилан: эмчлэгдэж байгаа, нас барсан
9. Дархлаажуулсан .....он .....сар.....өдөр.....цаг
10. Хийлгэсэн вакцины нэр.....  
Хэд дэх тун хийлгэсэн .....
11. Дархлаажуулсан газар/ эмнэлгийн нэр, гэрт ....гм/.....
12. Авсан арга хэмжээ .....

Мэдээлсэн хүний нэр ..... албан тушаал .....

Мэдээлсэн .....он .....сар.....өдөр.....цаг.....минут

Мэдээллийг хүлээн авсан хүний нэр .....,  
Албан тушаал .....

Эрүүл мэндийн сайдын 2012 оны  
оны 6 сарын 27 өдрийн 14.7  
тоот тушаалын дөрөвдүгээр  
хавсралт

ДДУХ-ийн судалгааны хуудас №-----

Судалгаа хийсэн ----- он ----- сар ----- өдөр

*Нэг. Хүн ам зүйн мэдээлэл*

1.	Өвчтөний овог нэр	
2.	Төрсөн он, сар, өдөр	
3.	Регистрийн дугаар	
4.	Хүйс	
5.	Гэрийн хаяг (тодорхой, дэлгэрэнгүй) Утасны дугаар	

*Хоёр. Тандалтын мэдээлэл*

6.	Вакцин тарихын өмнө хийсэн эмчийн үзлэгийн тэмдэглэл	
7.	Дархлаажуулалтыг хийсэн газар	
8.	Энэ өдөр дархлаажуулагдсан нийт хүүхдийн тоо	БЦЖ _____ Геп В _____ X/Caa 1 _____ X/Caa 2 _____ X/Caa 3 _____ X/Caa 4 _____ Тавт 1 _____ Тавт 2 _____ Тавт 3 _____ УГУ 1 _____ УГУ 2 _____ СТ1 _____ СТ2 _____ Геп А 1 _____ Геп А 2 _____ Бусад _____
9.	Тухайн өдөр хэрэглэсэн бүх вакцины нэр, тун, серийн дугаар, үйлдвэрлэгчийн нэр, хугацаа, шошгоны мониторын заалт	

*Гурав. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлын талаарх мэдээлэл*

10.	Урвал, хүндрэл эхэлсэн өдөр, цаг	
11.	Урвал, хүндрэлийг мэдээлсэн өдөр, цаг	
12.	Илэрсэн эмнэл зүйн шинж, төрх	
13.	Эмнэлэгт хэвтсэн он, сар, өдөр, цаг	
14.	Хэвтсэн эмнэлэг, тасгийн нэр Өвчний түүхийн дугаар	

	Өвчтөний тавилан Эмчилгээний хуулбарыг хавсаргах	
15.	Удмын байдал, жирэмслэлт, төрөлтийн явц, хүүхдийн бие сэтгэцийн өсөлт	
16.	Өвчилж байсан өвчинүүд, сүүлд хийсэн эмчилгээ	
17.	Харшил, багтраа, таталт урд нь тохиолдож байсан эсэх	
18.	Дархлаажуулалтын дараа уг өвчинтэй адил шинж тэмдэг урьд нь гарч байсан эсэх	
19.	Гэр бүлийн гишүүдэд уналт таталт/эпилепси, харшил, багтраа г.м өвчин буй эсэх	
20.	Гэр бүлийн гишүүдэд уг өвчинтэй адил өвчин урьд нь илэрч байсан эсэх	
21.	Үг урвал, хүндрэлтэй адил шинж тэмдэг бусад вакцин хийлгэсэн хүүхдүүдэд ажиглагдсан эсэх, тийм бол хаана, too	
22.	Үг урвал, хүндрэлтэй адил шинж тэмдэг бусад вакцин хийлгээгүй хүүхдүүдэд ажиглагдсан эсэх, тийм бол хаана, too	

*Дөрөв. Дархлаажуулалтын талаарх мэдээлэл*

23.	Дархлаажуулалтын кабинетийн өрөөний тоо	
24.	Дархлаажуулалт хийсэн сувилагчийн нэр	
25.	Сувилагчийн ажилласан жил	
26.	Сургалтад хамрагдаж үнэмлэх авсан эсэх	
27.	Хамгийн сүүлд хэзээ сургалтад хамрагдсан /хугацаа /	
28.	Вакцин найруулах техник ямар байсан /шалгалтаар /	
29.	Вакцин соруулах техник ямар байсан /шалгалтаар/	
30.	Байнгын цахилгаантай эсвэл тасардаг эсэх	
31.	Хөлдөөгчийн хэмийн заалт	
32.	Хөргөгчийн хэмийн заалт	
33.	Хөлдөлтийг тандах заагуурын (freeze tag) заалт	
34.	Хөлдөөгч, хөргөгчийн хэмийн тэмдэглэлийг өдөрт хоёр удаа тогтмол тэмдэглэсэн эсэх. /Тэмдэглээгүй бол хугацааг бич/	
35.	Вакцины шошгоны монитор өөрчлөгдсөн вакциныг бичих	
36.	Хөргөгчид вакцинаас өөр зүйл	

	хадгалсан эсэх? (Хэрэв тийм бол, хэзээ, хаана?)	
37.	Үлдэгдэл хүн тун вакцин, уусгагч шингэн, зүү тариур, найруулдаг зүү тариурын тоо	
38.	Хэрэглэж буй зүү тариурын хугацаа, үйлдвэрийн нэр	
39.	Шошгогүй вакцин байгаа эсэх	
40.	Вакцин болон уусмалыг хаана хадгалдаг эсэх	
41.	Хэрэглэсэн зүү тариур, үлдэгдэл вакцины устгалыг яаж хийдэг, бичих	

*Тав. Сэжиглэж байгаа вакцины тухай мэдээлэл*

42.	Сэжиглэж буй вакцины нэр, серийн дугаар, хүчинтэй хугацаа, үйлдвэрийн нэр	
43.	Хүлээж авсан вакцины хүн тун, тоо	
44.	Үлдэгдэл вакцины хүн тун, тоо	
45.	Задалсан вакциныг хүйтэн хэлхээний горимын дагуу хадгалсан эсэх	
46.	Сэжиглэж буй вакциныг задалсан огноо, цаг	
47.	Вакцин хийлгэсэн хүүхдийн тоо	
48.	Өвчтөн хэд дэхь тунг хийлгэсэн эсэх	
49.	Тухайн задалсан вакцинаар тариулсан хэддэх хүүхэд гэдгийг бичих	
50.	Вакциныг хэрэглэж дууссан сар, өдөр, цаг	
53.	Сэжиглэж буй вакцинаар дархлаажуулсан хүүхдийн нийт тоо.(Хүүхдийн нэр, нас, хүйс, гэрийн хаягийг бичиж хавсаргах)	
51.	Дархлаажуулалт хийсэн тухайн серийн вакцины шошгоны мониторийн (ВШМ) заалт (шалгалт хийх үед)	
52.	Хэрэв найруулсан вакцин бол уусгагч шингэний нэр.	

*Зургаа. Вакциныг явуулын дархлаажуулалтаар хийсэн тохиолдол*

53.	Вакциныг дархлаажуулалтын кабинетээс авсан өдөр, цаг	
54.	Тухайн хүүхдэд вакцин тарисан өдөр, цаг	
55.	Явуулын дархлаажуулалтын үеийн хэм заагуурын тэмдэглэл	
56.	Дархлаажуулалтын кабинетээс вакциныг зөөвөрлөсөн ажилтны нэр, албан тушаал	

57.	Явуулын дархлаажуулалтад хэрэглэсэн вакциныг тушаасан өдөр, цаг	
<i>Долоо. Лабораторийн шинжилгээний сорьцын мэдээлэл</i>		
58.	Задалсан үлдэгдэл вакцинаас лабораторийн шинжилгээнд явуулсан эсэх	
59.	Шинжилгээ хийсэн байгууллагын нэр, дүгнэлт	
60.	Задлаагүй ижил төрлийн хэдэн флакон вакцин, уусгагчийг лабораторийн шинжилгээнд явуулсан эсэх	
61.	Шинжилгээ хийсэн байгууллагын нэр, дүгнэлт	
62.	Шинжилгээнд явуулсан зүү тариурын тоо	
63.	Шинжилгээ хийсэн байгууллагын нэр, дүгнэлт	
64.	Буглаа, лимфоадениттэй өвчтөнд хийсэн шинжилгээний хариу, шинжилсэн байгууллагын нэр	
65.	Өвчтөнд хийсэн цусны шинжилгээ болон цус өсгөвөрлөх шинжилгээний хариу, шинжилсэн байгууллагын нэр	
66.	Тархи нугасны шингэнд хийгдсэн шинжилгээний хариу, шинжилсэн байгууллагын нэр	
67.	Нас барсан тохиолдлын эмгэг анатомийн шинжилгээний дүгнэлт, шинжилсэн байгууллагын нэр	

*Найм. ДДҮХ-ийн тандалтын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ*

68.	Үйл ажиллагааны алдаа (тодорхой дурьдах)	
69.	Вакцины урвал	
70.	ДДҮХ давхцаж илэрсэн	
71.	Шалтгаан тодорхойгүй	
72.	Эмнэлзүйн эцсийн онош	
73.	ДДҮХ-ийн тохиолдол мөн эсэх	
74.	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
75.	Зөвлөмж	

Судалсан эмч/мэргэжилтний нэр:

Албан тушаал, гарын үсэг:

Судалгаа дууссан .....он .....сар.....өдөр



Эрүүл мэндийн сайдын 2012 оны  
оны 6 сарын 20-дэдрийн  
төт тушалын тавдугаар  
хавсралт

ДЛЯХ-НИЙ БҮРТГЭЛИЙН ХҮЧАС

201—он—сар—өдөр

Баргууллагын нэр:

Эрүүл мэндийн сайдын 2012  
оны 6 сарын 27. өдрийн 27 тоот  
тушаалын зургаадугаар хавсралт

### ДДУХ-ийн лабораторийн шинжилгээ авах заавар

ДДУХ-ийг лабораториор баталгаажуулах, эсвэл ~~үүгүйсгэхийн~~ тулд шаардлагатай сорьцыг цуглуулан шинжилгээнд илгээх шаардлагатай. Шалтгааны талаарх таамаглал ямар байхаас шалтгаалан сорьцыг сонгоно.

#### Өвчтөнөөс авах сорьц

- Цус, шээс, тархи нугасны шингэн, шарх/ буглаанаас авсан арчдас,
- Өвчтөн нас барсан тохиолдолд задлан шинжилгээний сорьц, гистологийн шинжилгээнд зориулсан эдийн сорьц авна.

#### Дархлаажуулалтын нэгжид хэрэглэж буй вакцинаас авах сорьц

- ДДУХ илэрсэн хүүхдүүдэд хэрэглэсэн вакцины үлдэгдэл,
- Сэжиглэж байгаа вакцинтай нэг хөргөгчинд хадгалагдаж байсан задлаагүй, ижил төрлийн вакцин болон найруулах уусмалаас төлөөлүүлэн доорх байдлаар шинжилгээнд авна.
  - Тухайн эрүүл мэндийн байгууллагаас – 2 флакон
  - Төв агуулахаас 5 флаконыг тус тус авна.

#### Зүү, тариураас сорьц авах.

Ихэвчлэн тухайн тохиолдолд хэрэглэсэн зүү, тариурыг аюулгүйн хайрцганд хийж устгадаг тул шинжилгээнд авах боломжгүй байдаг. Иймээс тухайн дархлаажуулалтад хэрэглэсэнтэй ижил задлаагүй шинэ зүү, тариурыг шинжилгээнд авна.

#### ДДУХ-ийн тохиолдолд сорьц цуглуулах чиглэл

Тохиолдол	Өвчтөнөөс авах сорьц	Вакцин, уусгагч, зүү тариур
Хэсэг газрын хариу урвал: - Буглаа - Лимфоаденит	Арчдас, цус цус	Вакцин
Төв мэдрэлийн тогтолцоонд илрэх урвал хүндрэл: TMT-ны шинжүүд - Саажилтгүй - Саажилттай	TНШ, цус Өтгөн	Вакцин, уусгагч
Бусад: - Анафилакси - Хордлогын шок - Нас барсан	Цус, цусны ёсгөвөр задлангийн эдийн шинжилгээ	Вакцин, уусгагч, зүү, тариур

11

### Сорьц илгээх

- Бүх сорьцыг (өвчтөний болон вакцин, найруулах уусмал, зүү тариур) зориулалтын сав, полизтилен уутанд хийж, битүүмжлэн, шошго наана.
- Шингэн агууламж бүхий сорьцыг дээш харуулж байрлуулна.
- Төв лабораториид илгээхдээ мөстэй орчинд тээвэрлэнэ.
- Сорьцыг шинжилгээний дагалдах хуудасны хамт илгээнэ.

ДДУХ-ийн лабораторийн шинжилгээний дагалдах хуудас №

Өвчтөний овог нэр-----	Төрсөн -----он -----кар-----
---өдөр нас ----- хүйс-----	Хаяг-----
-----ДДУХ-ийн шинж тэмдэг илэрсэн -----он-----	
кар-----өдөр	
Сорьц авсан -----он-----кар-----өдөр	
Сорьц илгээсэн -----он-----кар-----өдөр	
Сорьцын дэлгэрэнгүй мэдээлэл (цус, ТНШ, өтгөн, зүү тариур, вакцин гэх мэт)	
Сорьцыг тээвэрлэсэн нөхцөл (хуурай мөс, мөстэй сав гэх мэт)	
Хийлгэх шинжилгээний нэр	
Эмнэл зүйн урьдчилсан онош	
Шинжилгээ явуулсан хүний нэр, албан тушаал	
Хаяг	утасны дугаар
Сорьц хүлээн авсан -----он-----кар-----өдөр, Хүлээн авсан хүний нэр-----	
Хүлээн авсан сорьцны байдал (дугуйлна уу): сайн, муу	
Шинжилгээний хариу	
Шинжилгээний хариу өгсөн : -----он-----кар-----өдөр	
Шинжилсэн эмчийн нэр:	Утасны дугаар
Шинжилгээ хийсэн байгууллагын нэр:	

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 6  
сарын 27 өдрийн 27 тоот тушаалын  
долоодугаар хавсралт

**Дархлаажуулалтын кабинетийн ажиллах журам**

Улс, хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эрүүл  
ахуй, халдвартын эсрэг дэглэм хангасан нөхцөлд дархлаажуулалтын арга  
хэмжээг зохион байгуулна.

Нэг. Эрүүл ахуйн нөхцөл, халдвартын эсрэг дэглэм

1. Дархлаажуулалтын кабинетийг 2-3 өрөөтэй байхаар зохион байгуулж,  
үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг Мэргэжлийн хяналтын  
байгууллагаас авсан байна.
2. Эрүүл хүүхдэд үйлчилдэг дархлаажуулалтын кабинетийг өвчтөний  
үзлэгийн өрөө, тасаг, палатаас ангид, тусдаа хаалгатай байхаар  
зохион байгуулна.
3. Дархлаажуулалтын кабинет нь дархлаажуулалт хариуцсан их эмчийн  
өрөө, сувилагчийн буюу вакцин тарих өрөө, эцэг, эх хүүхэдтэйгээ  
хамт байх хүлээлгийн буюу тоглоомын өрөөтэй байна. Хана тааз нь  
toson будгаар будагдсан байна.
4. Дархлаажуулалтын кабинетийн өрөө нь зохиомол гэрэлтүүлэг өдрийн  
150 люкс, ердийнх 75 люкс, байгалийн хангалттай гэрэлтүүлэгтэй,  
өрөөний хэм 20- 22 хэм, салхивчтай байна.
5. Вакцины сувилагч нь мэргэжлийн дамжаанд суралцсан, вакцин тарих  
арга техник эзэмшсэн гэрчилгээ (сертификат) авсан байна. БЦЖ  
вакцин тарих сувилагч жил бүр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан  
байна.
6. Төвлөрсөн халуун, хүйтэн усны системтэй бол кабинет нь гарын тохой  
эсвэл мэдрэгчээр ажилладаг угаалтууртай, бие засах газартай байна.
7. Төвлөрсөн бус усан хангамжийн системтэй бол кабинетуудад гар  
угаах энгийн угаалтуур байрлуулна.
8. Вакцин тариулахаар хүлээж буй хүүхдүүдийг тоглох, эцэг эхчүүд нь  
вакцины ач холбогдолын талаар мэдээлэл авах нөхцлийг хангахаар  
тохижуулсан байна.
9. Өрөөнүүдийг өдөр бүр угаалгын бодис болон халдвартгүйтгэлийн  
бодистой уусмалаар угааж цэвэрлэнэ.
10. Өрөө, тасалгаанд цаг тутамд салхивчийг нээж 10-15 минут цэвэр  
агаар оруулна.

11. Хог, хаягдлыг шар, улаан, хар өнгийн уут бүхий хөлөөр гишгэж онгойдог зориулалтын саванд, хэргэлсэн зүү тариурыг аюулгүйн хайрцганд хийж, хог хаягдлыг устгасан тухай тэмдэглэл хөтөлнө.

**Хоёр. Дархлаажуулалтын кабинетэд байх тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл**

1. Вакцин хадгалах зориулалтын хөргөгч, вакцин зөвөрлөх сав, хэм заагуур, хөлдөлтийг тандагч заагуур, мөсөн элемент зэрэг вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг байрлуулсан байна.
2. Компьютер, принтер, хувилагч машин, TV, DVD зэрэг сурталчилгааны техник хэрэгсэл, бичгийн цаас, үдэгч, үзэг, хавтас, сэргийлэх тарилгын карт хадгалах шүүгээ зэргээр тоноглосон байна.
3. Дархлаажуулалттай холбоотой хууль, тогтоол, тушаал, арга зүйн зөвлөмжийн эмхтгэл, гарын авлага, вакцин тарих заавар, сургалт, сурталчилгааны материал, сэргийлэх тарилгын карт, дархлаажуулалтын гэрчилгээ, вакцин биобэлдмэлийн орлого зарлагын дэвтэр, хэм тэмдэглэх дэвтэр, дархлаажуулалтын тайлангийн маягтууд байна.
4. Чагнуур, мэдрэлийн алх, даралтын аппарат, жин, өндөр хэмжигч, чих, хамар хоолойн толь, халууны шил, нэг удаагийн хэл дарагч, зэрэг багажаар хангаж эрүүл мэндийн байдалд үнэлэлт өгч, аюулгүй дархлаажуулах боломжоор хангана.
5. Нян устгагч гэрлийн аппарат, эмч, сувилагч, эх, хүүхдэд зориулсан ширээ, сандлууд, тэргэнцэр бүхий ширээ, өлгий вандан, зүү тариур, хямсаа, халад малгай, наалт, аюулгүйн хайрцаг, шингэн саван, хөлөөр нээгддэг хогийн сав, спирт, хөвөн, гутлын автомат углаашууд, халдвартгүйтгэх бодис зэргийг байрлуулна.
6. Адреналин, анальгин, атрофин, кордиамин, дексаметазон, преднизолон, седуксин, супрастин, эуфиллин, эфедрин, парацитамол зэрэг яаралтай тусламжийн эмүүд байна.

**Гурав. Дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг**

1. Дархлаажуулалтын кабинетийн эрүүл ахуйн нөхцөл, халдвартын эсрэг дэглэмд хяналт тавих.
2. Дархлаажуулалтад хамрагдвал зохих 0-15 насны хүүхдийн бүртгэл, судалгааг сум, өрхийн эмчээр гаргуулж, сар, жилийн тарилгын төлөвлөгөө хийж, хамралтыг нэмэгдүүлэх, хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах.
3. ДДУХ-ийн тандалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.
4. Дархлаажуулалтын кабинетийн сувилагчийн үйл ажиллагаанд хяналт тавих.

5. Дархлаажуулалтын сар, улирал, хагас, бүтэн жилийн тайлан, мэдээ гаргах,
6. Сум, өрхийн эмчийн дархлаажуулалтын хамралтад хяналт тавьж, эргэн мэдээлэх.
7. Дархлаажуулалт бүхий халдварт өвчин, ДДУХ бүртгэгдсэн тохиолдлуудад тархвар судалгаа, тандалт хийж эх уурхай, дамжсан зам, шалтгааныг тогтоох, хариу арга хэмжээг зохион байгуулах.
8. Дархлаажуулалтын хамралт, ДДУХ-ийн тандалтын талаарх тулгамдсан асуудлыг тодорхойлж, санал, дүгнэлт боловсруулан байгууллагын захиргаа болон холбогдох байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх.
9. Дархлаажуулалтын талаар эмч, сувилагч нарт сургалт тасралтгүй зохион байгуулах.
10. Дархлаажуулалтын кабинетийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, вакцин, зүү тариур, бичиг баримтын хөтлөлт, яаралтай тусламжийн эмийг захиалах, хангах, нөөцлөх, хадгалах, баталгаат унаагаар тээвэрлэх.
11. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлын мэдээ, мэдээллийг энэхүү тушаалын дагуу тархвар судлаач эмчид хугацаанд нь мэдээлж, эмч сувилагч нарт эргэн мэдээлэх.

Дөрөв. Дархлаажуулалтын кабинетийн сувилагчийн үүрэг

1. Сувилагч нь мэргэжлийн дамжаанд суралцаж, вакцин тарих арга техник эзэмшсэн гэрчилгээ (сертификат)-тэй байна. БЦЖ вакцин тарих сувилагч жил бүр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.
2. Дархлаажуулалтын кабинетийн ариун цэвэр, эрүүл ахуй, халдварын эсрэг дэглэмийг мөрдөж, бэлэн байдлыг хангах.
3. Нян устгагч гэрлийг дархлаажуулалт эхлэхийн өмнө 15-20 минут асаан өрөөг ариутгах, үйлчлүүлэгчдэд автоматаар өмсдөг углааш хэрэглүүлэх.
4. Засгийн газрын тогтоолоор баталсан Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг мөрдөн дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах.
5. Вакцин хадгалдаг хөргөгч, хөлдөөгчний хэмийн заалтыг өглөө, оройд хэмжиж тэмдэглэл хөтөлнө. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж ямар нэгэн гэмтлийн улмаас ажиллахгүй болсон байвал байгууллагын захиргаанд мэдэгдэж шийдвэрлүүлэх.
6. Дархлаажуулалт хийхийн өмнө гараасаа бөгж, цагийг авч дархлаажуулах бүрт гарыг шингэн савангаар сайн угааж, спирт агуулсан бодисоор халдвартгүйтгэх.
7. Гар шалбарсан, зүсэгдсэн, шархалсан, идээлсэн гэх мэт төрөл бүрийн гэмтэлтэй ямар ч тохиолдолд вакцин хийхгүй байх.
8. Хүүхдийн тоглоом бүхий өрөөнд эцэг, эхчүүдэд ямар вакцины хэддэх тунг хийх гэж байгаа, эмэнд, өндгөнд, хүнсний зүйлд, өмнө тариулсан

- ямар вакцинд харшил, урвал илэрсэн эсэхийг лавлан дархлаажуулалт хийсний дараа 30 минут байхыг зөвлөх.
9. Дархлаажуулалтын тухай хуулийн 13.3-д заасны дагуу эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид хийх гэж буй вакцины үйлдвэрийн зааврыг танилцуулж, дархлаажуулах зөвшөөрөл авах.
  10. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид вакцины шошгоны мониторын өнгө, дуусах хугацаа, серийн дугаар, тарих тун, тарих газрыг танилцуулж, зүү тариурыг харуулан задалж, соруулах.
  11. Хүүхдийг зөв бариулан тарих талбайг нярайг нэrmэл усаар, бохирдолтой бол 76<sup>0</sup>-ийн спиртээр халдвартгүйтгэн тарьж, зориулалтын наалтыг нааж бохирдоос хамгаалах.
  12. Хэрэглэсэн зүү тариур, үлдэгдэл вакциныг устгасан тухай тэмдэглэл хөтлөх.
  13. Вакциныг зориулалтын унаагаар тээвэрлэн авч, орлого зарлагын тооцоог өдөр тутам хийж, мэдээ тайланг тогтоосон хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлэх.
  14. ДДУХ тохиолдол бүртгэгдсэн үед шаардлагатай мэдээ, мэдээллийг судалгааны багт гаргаж өгөх.
  15. Дархлаажуулсан хүүхдэд 5 хоногийн хугацаанд дархлаажуулалтын сувилагч хяналт тавьж, ДДУХ-ийн тандалт хийх.